



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 07/20

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” 03 тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсантай холбогдуулан ажлын байрны чиг үүргийн шинжилгээ хийж албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Н.Түвшинжаргал (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Э.Одончимэг (Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Н.Сүхбаатар (Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Ж.Уянга (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Х.Мөнхсаруул (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

2. Албан тушаалын тодорхойлолтыг холбогдох дүрэм журмын дагуу боловсруулан Төрийн албаны зөвлөлөөр хянуулан батлуулахыг ажлын хэсэг (Н.Түвшинжаргал)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ДОРЖБАТ

4822150160